



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2025. 01. 04 № 1/04

танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн мэдээг, түүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн хамт хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.



О.ПҮРЭВДОРЖ

6225 15 0018

D:My Doc. A5 albanbichig /ZD/

Аймгийн Засаг даргын 2025 оныг 07... дүгээр
сарын 07...-ны өдрийн 07... дугаар
албан бичгийн хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС 2024 ОНД ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

2025.01.06

Арвайхээр

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандан ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, Засгийн газрын 2005 оны "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдон зарим арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны "Журам батлах тухай" 44 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан "Иргэдээс аймаг, сумын Засаг дарга түүний Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журмыг тус тус хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, агентлаг, төсөвт байгууллагуудад хандаж иргэдээс нийт 13673 санал, хүсэлт, гомдол ирүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 50.0 хувиар буурсан байна. Учир нь салбарын хууль тогтоомжид заасны дагуу иргэний бүртгэл, нийгмийн халамж, газрын харилцаа зэрэг байгууллагуудаас төрийн үйлчилгээг үзүүлэхэд иргэдээс зайлшгүй авдаг хүсэлтийг төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээнд тусгаагүй.

Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг ирүүлсэн сувгаар нь авч үзвэл: Иргэн өөрийн биеэр 8163, байгууллагын тусгай утасны дугаараар холбогдож 780, байгууллагын вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл зэрэг цахим хэлбэрээр 1951, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 101, иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдээс албан бичгээр 2678 иргэн санал, хүсэлт, гомдол ирүүлсэн байна. Түүнчлэн нийт ирүүлсэн 13673 санал, хүсэлт, гомдлыг төрлөөр нь авч үзвэл: Хүсэлт 13094 буюу 95.1 хувь, гомдол 410 буюу 3.6 хувь, санал 169 буюу 1.2 хувийг тус тус эзэлж байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирүүлсэн нийт 13673 санал, хүсэлт, гомдлоос 2966 буюу 21.6 хувийн албан бичгээр, 1676 буюу 12.2 хувийг цахимаар, 2184 буюу 15.9 хувийг утсаар, 6801 буюу 49.2 хувийг биечлэн хариуг өгч, хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Мөн 36 иргэний хүсэлтийг холбогдох харьяаллын дагуу Улсын бүртгэлийн байгууллага, Татварын хэлтэс, Цагдаагийн газар төрийн өмчит компани, эрүүл мэндийн байгууллага, зэрэгт шилжүүлэн шийдвэрлүүлсэн. Хүлээгдэж буй 13 иргэний ирүүлсэн хүсэлт байна.

Нийт ирүүлсэн санал, хүсэлт, гомдлын агуулга, шийдвэрлэх хугацаа зэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд: нийгмийн халамж үйлчилгээтэй холбоотой өргөдөл 21 хувь, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүсэлт 11 хувь, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой 12 хувь, тусламж дэмжлэг хүссэн 13 хувь, боловсролын үйлчилгээтэй холбоотой 17 хувь, амьдрах орчин нөхцөлтэй холбоотой 15 хувь нь ирүүлсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны хувьд ажлын 3-5 хоногт нийт өргөдлийн 20 хувийг, ажлын 5-30 хоногт 50 хувийг, 30-60 хоногт 30 хувийг шийдвэрлэсэн байна. Мөн аймгийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудын долоо хоног бүрийн Шуурхай хуралдаан 2024 онд нийт 34 удаа хуралдаж, төрийн үйлчилгээ мэдээллийн төвөөр дамжуулан иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, түүний шийдвэрлэлтийн байдлыг хэлэлцэж, аймгийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өргөдөл, гомдлын мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлж үүрэг чиглэлийг тухай бүр өгсний дагуу бүх шатны төрийн байгууллагууд хэрэгжилтийг хангаж ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Аймгийн Засаг даргын Тамгын газар 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 259 иргэний хүсэлт, гомдлыг бүртгэж авсан байна. Үүний 258 нь хүсэлт, 1 гомдол байна. Хуулийн хугацаанд албан бичгээр 3 иргэний, холбогдох утсаар нь 60 иргэний, биечлэн 191

иргэний хүсэлтийг шийдвэрлэн нийт 254 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэх шатандаа буюу хуулийн хугацаа болоогүй 5 иргэний хүсэлтийг судалж байна. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл: Мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 125, ажилд орох, ажлын байраар хангахыг хүссэн 53, төрийн шагналд уламжлахыг хүссэн 30 хүсэлт байна. Эдгээрийг ажлын 1-30 хоногт багтаан шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдол нь өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Энэ оны жилийн эцэст аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд иргэдээс нийт 59 хүсэлт ирүүлсэнийг биечлэн шийдвэрлэсэн байна. дээрх 59 хүсэлт нь агуулгын хувьд тусламж дэмжлэг хүссэн өргөдөл байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага

Энэ оны жилийн эцсийн байдлаар нийт 11918 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч бүртгэл судалгаа, шинжилгээн дээр тулгуурлан шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг өмнөх онтой харьцуулан үзэхэд 43.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг ирүүлсэн байдлаар нь авч үзвэл: Өөрийн биеэр 7148, байгууллагын тусгай утсаар 762, байгууллагын вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл зэрэг цахим хэлбэрээр 1901, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 51, албан бичгээр 2056 иргэн өргөдөл, гомдлоо ирүүлсэн. Үүнийг шийдвэрлэсэн байдлаар нь ангилан үзэхэд: 2361 иргэний хүсэлтийг албан бичгээр, 1653 иргэний хүсэлтийг цахимаар, 2019 иргэний хүсэлтийг холбогдох утсаар, 5864 иргэний хүсэлтийг биечлэн хариуг нь өгч шийдвэрлэсэн байна. Бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 21 иргэний хүсэлт байна. Энэ харьяаллын дагуу шилжүүлсэн хүсэлтийг Тодруулбал: Нийгмийн даатгалын газарт 3, Боловсролын газарт 8, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудад 7, Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Станц-Төрийн Өмчит ХК-д 3 иргэний үйлчилгээ авах хүсэлтийг удирдлагын цохолт албан бичгээр шилжүүлсэн байна. Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар болон төсөвт байгууллагуудад нийт 322 гомдол иргэдээс ирүүлсэн бөгөөд үүнийг агуулгаар нь авч үзэхэд: байгууллагын ажилчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдол 41, амьдрах орчин нөхцөлтэй холбоотой 178, цахилгаан эрчим хүчтэй холбоотой 33, Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой 30 гомдол, худаг усан сантай холбоотой 40 гомдол тус тус ирсэн байна. Дээрх гомдлын мөрөөр дүн шинжилгээ хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон тухайн гомдол гаргасан иргэнд хуулийн хугацаанд 30 хоногт багтаан тайлбар хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд 2024 оны жилийн эцэст нийт 1437 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэдэд үйлчилсэн байна. Нийт өргөдөл гомдлыг хүлээн авсан хэлбэрээр нь ангилан үзэхэд: иргэн өөрийн биеэр 699, 18 иргэн утсаар, 50 иргэн цахимаар, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 50 иргэн, албан бичгээр 620 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авсан. Иргэдээс агентлагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзэхэд санал 34, гомдол 87, хүсэлт 1316 бүртгэгдсэн байна. Үүнээс нийт ирүүлсэн гомдлыг байгууллагаар нь авч үзвэл: Боловсролын газарт 45 гомдол, Эрүүл мэндийн газарт 25, Цагдаагийн газарт 13, Хүнс хөдөө аж ахуйн газарт 3, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт 1 гомдол тус тус ирүүлснээс дээрх байгууллагууд 74 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Боловсролын газраас 11 гомдлыг харьяаллын дагуу хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 2 гомдлыг судлан үзэж байна. Нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 73.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс тус аймагт хамааралтай гаргасан иргэний хүсэлт, гомдол нийт 101 бүртгэгдсэн. Үүнээс гомдол 88, хүсэлт 6, санал 7 байна. Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2024 онд нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг өмнөх онтой харьцуулахад 14.4 хувиар буурсан байна. Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзэхэд: 85 иргэний гомдлыг утсаар, 16 иргэнийг гомдлыг албан бичгээр тус тус шийдвэрлэсэн байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ИРГЭДЭЭС 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СТАТИСТИК МЭДЭЭ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Үүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	1	-	258	257	-	-	-	2
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал				59	59				
Агентлагууд		87	34	1316	699	18	50	50	620
Сумдын Засаг даргын Тамгын газар		322	135	11461	7148	762	1901	51	2056
Нийт	-	410	169	13094	8163	780	1951	101	2678

2023 ОН

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл					Үүлээн авсан хэлбэр			
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	2	-	195	197	-	-	-	-
Агентлагууд	-	72	1	5501	4283	63	936	62	230
Сумдын Засаг даргын Тамгын газар	-	329	171	20934	18035	1001	2042	56	300
Нийт	-	403	172	26630	22515	1064	2978	118	530

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны жилийн эцэс шийдвэрлэлт

Шийдвэрлэлтийн байдал										
ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
					Аймгийн Засаг даргын Тамгын газар	3		60	191	-
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал				59						
Агентлагууд	602	23	102	687	13	2	-	-	8	-
Сумдын Засаг даргын Тамгын газар	2361	1653	2019	5864	21			-		
Нийт	2966	1676	2181	6801	34	2	0	0	13	0

2023 ОН

ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
Аймгийн Засаг даргын Тамгын газар	1	2	3	4	5	6	7	8	9	10
	-	-	-	140	46	-	-	-	11	-
Агентлагууд	-	-	-	5357	12	-	2	-	203	-
Сумдын Засаг даргын Тамгын газар	-	-	-	20625	611	-	-	-	198	-
Нийт	-	-	-	26122	669	-	2	-	412	-

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ БАЙДЛААР ИРТЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААГ ТАНД ХАНДАЖ
ГАРГАСАН ГОМДОЛ (Агуулгаар)

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Боловсролын байгууллага үйл ажиллагаатай холбоотой	43	10.98	
2	Орчны бохирдолтой холбоотой гомдол	178	43.41	
3	Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол	40	9.76	
4	Худал, усан сантай холбоотой гомдол	40	9.76	
5	Зам талбай, замын тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио, гарцтай холбоотой	53	12.93	
6	Цахилгаан эрчим хүчтэй холбогдолтой үйлчилгээ	33	8.05	
7	Бусад	21	5.12	
8	Нийт	410	100.00	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар сургалт мэдээлэл өгөх, арга зүй олгох

2023 он

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Боловсролын асуудлаар	35	8.68	
2	Эрүүл мэндийн чиглэлээр	28	6.95	
3	Орчны бохирдолтой холбоотой гомдол	220	54.59	
4	Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол	61	15.14	
5	төрийн албан хаагчийн харилцаа, хандлагаатай холбоотой	25	6.20	
6	төрийн үйлчилгээтэй холбоотой	34	8.44	
7	Нийт	403	100.00	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

2025.01.07

Арвайхээр


Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж хариу өгсөн байдал, өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ.

Энэ хүрээнд аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн 27205, 2024 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн 13614 өргөдөл, гомдол, саналын агуулга, шийдвэрлэлтийн хувийг харьцуулан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсрууллаа.

Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 27205 өргөдөл, гомдол, санал ирсний 26144 буюу 96.1 хувь нь шийдвэрлэгдсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 13614 өргөдөл, гомдол, санал ирсний 13565 буюу 99.6 хувь нь шийдвэрлэгдсэн байна.

НЭГ. ГОМДЛЫН АГУУЛГА

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2023, 2024 онуудад ирүүлсэн гомдлын агуулгын эзлэх хувийг дараах хүснэгтэд харьцуулан харуулав. (хамгийн өндөр хувьтай гомдлын агуулгаар)



Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гомдлын дийлэнх хувийг боловсролын байгууллагын үйл ажиллагаа, орчны бохирдол, нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол эзэлж байна.

Дээрх агуулгын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын дагуу төрийн байгууллага өөрийн харьяалан шийдвэрлэвэл зохих гомдолд дурдсан асуудал бүрд дүн шинжилгээ хийж, холбогдох газраас магадлах, судалгаа, тодорхойлолт шаардан авах зэрэг үйл ажиллагаа явуулан шийдвэрлэн ажиллаж байгаагийн үр дүнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь өндөр байна.

ХОЁР.ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУВЬ

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2023, 2024 онуудад ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэсэн хувийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Шийдвэрлэлтийн хувь	2023	2024
100		99.6
99		
98		
97		
96		96.1
95		
94		

ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУВЬ

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүргийн дагуу шийдвэрлэж ажилласан бөгөөд шийдвэрлэлтийн хувийг харьцуулвал 2024 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь 2023 оноос 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтан өргөдөл, гомдлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол зохих шийдвэрийг гаргана хэмээн заасны дагуу тодорхой чиглэлийн асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн ажилласан нь шийдвэрлэлтийн хувь өндөр байхад нөлөөлж байна.

ГУРАВ.ХҮЛЭЭН АВСАН БОЛОН ШИЙДВЭРЛЭЖ ХАРИУ ӨГСӨН ХЭЛБЭР

Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, саналын 80.0 орчим хувь нь бичгээр ирсэн бөгөөд шууд шийдвэрлэх боломжгүй, удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал (орон сууц олгуулах гэх мэт)-аар гаргасан өргөдлөөс бусад өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тохиолдолд хариуг бичгийн тохиромжтой хэлбэрээр мэдэгдэхээс гадна биечлэн буюу харилцах утсаар нь өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан мэдэгдэж хэвшсэн байна.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөхдөө бичгээр болон утсаар хариу мэдэгдэх хэлбэр дийлэнх хувийг эзэлж байна.

Дүгнэлт:

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, тэдгээрийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж, хариу өгсөн байдалд хяналт-шигнэлт хийхэд холбогдох хуулийн дагуу өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэж, хариуг зохих хэлбэрээр мэдэгдэн ажилласнаар аймгийн хэмжээнд 2023, 2024 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн нийт 40819 өргөдөл, гомдол, саналын 97.2 хувь нь шийдвэрлэгдсэн байна.

Цаашид нутгийн захиргааны байгууллагууд тухайн байгууллагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх нь утга агуулга ижил бүхий асуудлаар хандсан өргөдөл, гомдлын тоо буурах боломжтой гэж үзлээ.


Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:

-Төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хяналт тавих

-Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэхэд холбогдох байгууллагатай харилцан уялдаатай ажиллах

-Холбогдох хуулийн дагуу нутгийн захиргааны бүх шатны байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдээлж ажиллах

-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нээлттэй байршуулж хэвших
-Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудын өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд
явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС